

**Үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын
айг шинжлэх нь**

Бао Вен Фен*

ӨМИС-ийн МСДС-ийн докторант

Агуулгын товч: Тус өгүүлэлд үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын айн хэрэглээний онцлогийг эрдэмтэн мэргэдийн судалгааны бүтээл дэх тодорхойлолтогтой уялдуулж, жишээлэн тодруулсны дагуу өмнөх судлаачдын үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын айн судалгааны бүтээлд төдийлөн дурдагдаагүй бүр мөсөн үйлдэх байдлын утгыг илтгэх [-ʃʰik, -ʃʰək], үйлдэсхийх байдлын утгыг илтгэх [-βɛskə:], давтан үйлдэх байдлын утгыг илтгэх [-a:tli: /-ə:tli: /-ɔ:tli: /-o:tli:], үргэлжлэн үйлдсээр байх байдлын утгыг илтгэх [-sa:r pɛ: /-sə:r pɛ: /-sɔ:r pɛ: /-so:r pɛ:] зэрэг дагаврын тухай судалж, эрдэмтдийн бүтээлд тайлбарласан үйл үгийн байдлын айн зарим дагаврын тухай саналаа дурдав.

Түлхүүр үг: үзэмчин аман яриа; үйл үгийн байдлын ай; хэрэглээний байдал

Үзэмчин аман яриа нь Цахар, Сөнөд, Авга, Хишигтэн, Шилийнхот, Дөрвөд, Урад, Дархан Муумянган зэрэг газар орны монголчуудын хэл яриатай хамт цахар аман аялгуунд багтдаг. Үзэмчин аман ярианд Монгол улсын Сүхбаатар аймаг, Дорнод аймагт аж төрж бүхий үзэмчин монголчуудын хэл яриаг ч багтаадаг. Анх 1911 онд А.Руднеев “Дорнод монголын аман аялгуунуудын материал” гэх зохиолдоо үзэмчин аман аялгууны тухай цухас дурдаж, түүнээс хойш дотоод, гадаадын монголч эрдэмтэд энэ аман аялгууг сонирхон судалсаар ирсэн юм. (Хөхбарс, 1991). Өвөр Монголд үзэмчин аман яриаг хамгийн нарийн судалсан бүтээл гэвэл Хөхбарс, Чимгээ хоёрын “Үзэмчин аман аялгуу” (1997 он) болно. Уг бүтээлд үзэмчин аман ярианы авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй ба үгсийн санг судалжээ. Үүнээс гадна, их, дээд сургуулийн оюутнууд үзэмчин аман яриаг судалсан өгүүлэл зохиол туурвин бичиж, үзэмчин аман ярианы судалгааг улам ахиулжээ. Гэтэл үзэмчин аман ярианы хэлний зүйн талаар тусгай судалгаа хийсэн хүн маш цөөн байна. Энэ байдалд чиглүүлэн үзэмчин аман ярианы судалгааг улам гүнзгийрүүлж, монгол хэлний хам цагийн судалгаанд өчүүхэн ч гэсэн нэмэр болохын тусад уг өгүүллийг бичив.

* © Бао Вен Фен 2024
Email: 2892120697@qq.com

Тус өгүүллийг зохиогч нь Өвөр Монголын их сургуульд магистрын зэрэг хамгаалсан өгүүллийнхээ суурин дээр туурвин бичсэн бүтээл бөгөөд судалгааны эх хэрэглэгдэхүүний хувьд өмнөх эрдэмтэн мэргэдийн судалгааны бүтээлд үндэслэсний дагуу 2021, 2024 онд Өвөр Монголын Шилийн гол аймгийн зүүн, баруун Үзэмчин хошуунд биечлэн хүрч, аман ярианы судалгаа хийсэн ба урд өмнөх судалгааны үзэмчин аман ярианы шингээлтийн материалд тулгуурлаж, байцаан судлах арга ба байдлыг тодорхойлох аргаар голлож, харьцуулах аргаар дэдлүүлж, үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын айн хэрэглээний онцлогийг шинжилсэн байна. Өгүүлэлд үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын айг дагаврын аргаар үзүүлэх байдлын ай, туслах үгийн аргаар үзүүлэх байдлын ай, давталтын аргаар үзүүлэх байдлын ай гэх гурван хэсэгт төрөлжүүлэн тодруулжээ. Үүнд байцаалтын цагийн хязгаарлагдмал ба эл зүйлийн нөхцөлөөс шалтгаалан тус өгүүлэлд үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын дагаврыг бүрэн илрүүлж чадаагүй байж магадгүй. Хожмын судалгаанд энэхүү дутагдлаа нөхвөрлөхийг хичээе.

Тухайн үйлийг үйлдэж байх шинж байдал нь ямар байх, тухайн үйл нь ямар шинж байдалтай болж байхыг заадаг хэл зүйн айг үйл үгийн байдлын ай гэнэ. Байдлын айг тусгай дагавраар илтгэхээс гадна бас үйл үгийг давтах арга ба туслах үгийн аргаар илтгэж байдаг. (На.Гэрэлт, 1998: 215). Үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын айн утгыг монгол бичгийн хэлнийх шигээр үйлдчих, үйлдэгдэх, дахин дахин үйлдэх, үйлдэхсийх, үргэлжлэн үйлдэж байх, дахин үйлдээд байх, үргэлжлэн үйлдсээр байх, удаан үргэлжлэх, удтал үргэлжлэх, олонтоо дахин үйлдэх байдал гэх мэтчилэн хувааж болох бөгөөд мөн дагаврын арга, туслах үгийн арга, давталтын аргаар илтгэдэг.

Нэг. Дагаврын аргаар байдлын айг илтгэх

Үзэмчин аман ярианы дагаврын аргаар илтгэх байдлын айд үйлдчих, үйлдэгдэх, дахин дахин үйлдэх, үйлдэхсийх байдал багтана. Байдлын айн дагаврыг үйл үгийн янз бүрийн үндсэнд (үүсмэл бус үндэс, үүсмэл үндэс, хэвт үндэс) бүр залгаж болно. Үүнд хэвийн дагаврын дараа байдлын дагавар залгаж болно, залгахгүй байж ч болно. Харин байдлын дагавар нь ер хэвийн дагаврын өмнө орж хэрэглэгддэггүй юм. Доор нэгд нэгээр жишээлэн тодруулъя.

1.1. Бүрмөсөн үйлдэх байдал

Үйлдчих байдлын дагаврыг хэлний зүй бүхэнд “нэгмөсөн үйлдчих” байдлын дагавар гэж үзэхээр барахгүй, зарим хүмүүс “-ж орхи” хэмээх энгийн холбох нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн “-ж”-ийн дараа туслах үйл үг “орхи” орж, задлаг хэлбэрээс бүрэлджээ гэж үздэг. (Батгэрэл, 1995). Үзэмчин аман ярианы үйлдчих байдлын утгыг [-ʃʰix, -ʃʰik, -ʃʰək] дагавраар илтгэж, бичгийн хэлэнд “čiq-a, čike, čig”-ээр үзүүлдэг. Жишээлбэл:

tʰi:m pəl pi: tu:ta:t okʃʰiki:, tʰAnʊ:s o:ro:n jerəlʃʰʰik.

Тийм бол би дуудаад өгчихье. Тануус өөрөө ярилцчих.

ʃʰi: tʰərt tɛŋxʊɑ: ʌβɑ:t xəlʃʰix.

Чи тэрэнд динхуа аваад хэлчих.

Mətʰu: ɕ:ləkkʰʊ:kɑ:n ʃʰɛkta:n ʌsʊ:ʃʰix.

Мэдэхгүй, ойлгохгүйгээ цагтаа асуучих.

mali:ʃʰin ɔtʊ: pur tʰɛr xurə:nt malʃʰɛksən ʊʃʰira:s jix tukum pəlʃ.

Малыг чинь одоо бүр тор хүрээнд малжчихсан учраас их дөхөм болж.

Үзэмчин аман ярианы үйлдчих байдлын утгыг [-ʃʰix, -ʃʰik, -ʃʰɛk] дагавраар илтгэнэ. Үүнд, Хөхбарс, Чимэг хоёрын “Үзэмчин аман аялгуу” гэх ном ба урд өмнөх зарим үзэмчин аман ярианы судалгааны бүтээлд үйлдчих байдлын утгыг [-ʃʰix, -ʃʰɪʃʰ] дагавраар илтгэнэ гэж үзсэн, гэвч тус удаагийн байцаалтад [-ʃʰɪʃʰ] дагавар илэрсэнгүй, харин [-ʃʰik, -ʃʰɛk] гэдэг дагавар илэрсэн байна.

1.2. Үйлдэгдэх байдал

Үйлдэгдэх байдлын утгыг илтгэх [-ɑ:tʰɑx /-ə:tʰəx /-ɔ:tʰɔx /-o:tʰox] дагаврын үүслийг авч үзвэл “-аад, -ээд + дэх”-ийн нийлмэл хэлбэрийн уялдал гэж үзэж болох юм. Даруй нөхцөл үйлийн урьдчилах “-аад, -ээд” гэсэн хэлний үзүүр -буйлны түрэлтгүй хамжих “д” [d] гийгүүлэгчээр төгссөн дагаврын дараа “та” [t]-аар эхэлсэн үгийг залгахад [d] нь балархайшин гээгдэж, “аа + дах” хэлбэр болж, уялдан нийлээд “-аадах, -ээдэх” дагавар болж бүрэлджээ. (Батгэрэл, 1995). Тус дагавраар хүсэмжлэн эрмэлзсэн утга бүхүй үйлдэгдэх байдлын утга илтгэдэг. Үзэмчин аман ярианы үйлдэгдэх байдлын утга илтгэх [-ɑ:tʰɑx /-ə:tʰəx /-ɔ:tʰɔx /-o:tʰox] дагаврын дараа [-tɑ:ʰ, -ə:ʰ] зэрэг сул үгийг залган хэрэглэж, хүсэмжлэн эрмэлзсэн санаагаа улам гүнзгийрүүлэх үзэгдэл бий. Жишээлбэл:

ʃʰi: mut ʊʃʰirkʊ: pəl mini: xɕeni: xurə: xɑɣɑ:tʰɑx.

Чи мөд учиргүй бол миний хонийг хүрээд хараатах.

Өн нэхэ: nɛk ʊ:lni: kurə:si: pɛɣɑ: irə:tʰɪx.

Энэ нохой нэг уулны гөрөөсийг бариад ирээтэг.

ɕ:rʰ jix kɑŋ tʰɛ: ʊʃʰira:s ʃʰɛ:xən pɛrɔ: ɔrɔ:tʰɔx kəʃ xusʃi:n.

Ойрд их гантай учраас жаахан бороо ороотохоо гэж хүсэж байна.

ʃʰi: xurə:t tʰɛr xɕeni: ʃʰɑ:ʃi:n xɔ:ko:tʰok .

Чи хүрээд тэр хонийг цаашаа хөөгөөтөх гэх мэт.

Энэ нь мөн ч хорчин зэрэг зүүн орны монголчуудын аялгуунд илэрдэг нэг зүйлийн үйлээс үйлийг бүтээх дагавар болно. (Батгэрэл, 1995). Үйлдчих байдлын дагавар хийгээд үйлдэгдэх байдлын дагавар нь утга илтгэмжийн хувьд хэдийгээр хоёрдугаар биед шаардаж захирсан утга үзүүлдэг боловч үгийн өнгөн дээрээ бага зөрөөтэй байдаг. Үүнд, голдуу үйлдэгдэх байдал бага сага эрмэлзсэн утга бүхүй өнгөтэй.

Үзэмчин аман ярианы үйлдэгдэх байдлын утга илтгэх [-ɑ:tʰɑx /-ə:tʰəx /-ɔ:tʰɔx /-o:tʰox] дагаврыг хааяа бас [salkɑ:tʰɑk tɑ:] (салгаатах даа), [itə:tʰɪkɔ:] (итгээтэх ээ), [nɔʃʰɔ:ko:tʰɔkɔ:] (ноцоогоотох оо), [oko:tʰoko:] (өгөөтөх өө) гэх мэтчилэн [-ɑ:tʰɑk /-ə:tʰɛk /-ɔ:tʰɔk /-o:tʰok] дагаврын дараа сул үг [-tɑ:ʰ, -ə:ʰ] дагуулан хүсэн эрмэлзсэн санаагаа улам нэмэгдүүлдэг.

1.3. Дахин давтан үйлдэх байдал

Үзэмчин аман ярианд дахин дахин үйлдэх байдлын утгыг үйл үгийн үндсэнд [-l] дагавар залгаж үзүүлдэг. Энэ нь үндсэндээ бичгийн хэлнийхтэй адилавартай байж, голдуу ямар нэгэн үйлийг дахин дахин үйлдэх санааг үзүүлэх тусах, эс тусах үйл үг үүсгэнэ. Жишээлбэл:

T^hər mət ʃ^hin səlχənt ʃ^həxəktə:t nA:ʃi:n ʃ^hA:ʃi:n sAʃi:lʃɛ:n.

Тэр мод чинь салхинд цохигдоод нааш цааш сажилж байна.

əmʃ^h xun pəl ʃ^hini: sətəl nɛ:ʃ^hin ʃ^həxəlχə:rən mətʃi:n.

Эмч хүн бол чиний судлын чинь цохилохоор нь мэдэж байна.

ə:ʃ nʊ:rɲɛ: t^hər tAβsi: ʃ^hin xəlɔ:s xAɣβəl kələlʃɛ:n.

Ээж нуурын тэр давсыг чинь холоос харвал гялалзаж байна.

Erəx jix ʊ:sən ʃ^hin nɛ:kəlʃA:t pəlkhʊ:.

Архи их уусан чинь найгалзаад болохгүй гэх мэт.

Дахин дахин үйлдэх байдлын утгыг илтгэх [-l] дагавар нь олон чадавхтай бөгөөд олонтоо үйлдэх ба эсэхийг бүр илтгэх үйлдэлтэй боловч үйл үндэс ба бүтэн язгуураас олонтоо үйлдэх үндэс бүтээхдээ заавал тусах шинжтэй байдаг. Харин бусад үндэснээс үйл үндэс бүтээхдээ тусах, эс тусахыг ялгадаггүй байна. (Ц.Норжин, 1991).

1.4. Үйлдэсхийх байдал

Монгол хэлний үйлдэсхийх байдлын “схий, бх” зэрэг дагавар нь цөм дүр дүрслэх дайвар болгох “с, б” дагавар авсан “хий” мөн тул үйлийн бүтэн язгуураас үйл үндэс бүтээнэ гэж эрдэмтэд үзэцгээдэг. Үзэмчин аман ярианд үйлдэсхийх байдлын утгыг бичгийн хэлнийх шигээр [-skə:], [-βkə:] дагавраар үзүүлдгээс гадна [-βkə:], [-skə:] дагаврын нийлбэр болох [-βəskə:] хэлбэрээр ч үзүүлдэг. Тус дагаврыг үйл үгийн үндэс ба зарим дайвар үгэнд шууд залгаж болно. Тухайн үйл үгээр илэрсэн үйлийг хоромхон үйлдэх байдлыг заасан үйл үгийн үндэс үүсгэнэ. (Ш.Лувсанвандан, Л.Болд, 1991:286) . Жишээлбэл:

Tən təɲɲɛ: kərlə:s xun xəti: ʃɛ:ləskə:tɛ:βəl nutɯn xAɣʃ^hən t^həti: sɛ:n pələn.

Дияан дэнгийн гэрлээс хүн хэдий зайлсхийгээд байвал нүдний харц нь төдий сайн болно.

T^hər t^hən sʊ:kA:t uʃʃɛ:t^hɯr nək putu:n ʃʊβʊ:nɛ: tə:r nAβ^həskə:t nək jim ə:ʃ^hiʃʃ^h.

Тэр тэнд суугаад үзэж байтал нэг бүдүүн шувууны дээр навтасхийгээд нэг юм ойччихжээ.

ən purku:t ɔtɔ: nisɯn kəʃɛ:x uit AɣA:sən tAβkə:t At^hkA:t Aβʃ^h.

Энэ бүргэд одоо ниснэ гэж байх үед араас нь давхийгээд атгаад авчихжээ.

T^hər ʃ^həssən xʊʃ^hɯn tən ɛ^həβkə:t ʃ^hA:ʃi:n tʊt^hA:tʃ^h.

Тэр цочсон хүчиндээ адавхийгээд цаашаа дутаачихжээ.

T^hər ʃ^hA:t^hɛ: nək kəɣl ʊlβəskə:t xAɣəktən ɛtəl.

Тэр цаатай нэг гэрэл улвасхийгээд харагдсан адил.

ʃ^hA:n nək mʊ:xɛ: tʊ: kAɣsən t^hər ʊɣβəskə:t kuikə:t pəsi:tʃ^h.

Цаана нэг муухай дуу гарсан тэр урвасхийгээд гүйгээд босчихжээ гэх мэт.

Тус дагавар нь бас доороо үйл үндэс бүтээх дагавар давхарлан авахгүй нөхцөлд “дулс дулс хийх ; бурс хийх” гэх мэтчилэн салангид бичигдэнэ. Үйлдэсхийх байдлын [-skə:], [-βkə:], [-βəskə:] дагавар нь урд өмнөх үзэмчин аман ярианы судалгааны бүтээлд илэрсэнгүй, нэн ялангуяа [-βkə:], [-skə:] дагаврын нийлбэр болох [-βəskə:] хэлбэр нь урд өмнөх хэлний зүйн ном зохиолд ч ер дэмий дурдагдаагүй, тус удаагийн байцаалтаар илрүүлсэн дагавар болно.

Хоёр. Туслах үгийн аргаар байдлын айг илтгэх

Үзэмчин аман ярианы туслах үгийн аргаар үзүүлэх байдлын айд голдуу үргэлжлэн үйлдэж байх, дахин үйлдээд байх, үргэлжлэн үйлдсээр байх байдал багтана. Туслах үгийн аргаар үзүүлэх байдлын айн утга илтгэмжийн тухай Өвөр Монголын их сургуулийн Дундад улсын хэл бичиг, утга зохиолын салбарын монгол хэлний тасгаас найруулсан “Одоо үеийн монгол хэл” (1964 он) гэх номд байдлын утгыг үзүүлдэг туслах үг нь “бай” гэдэг үйл үг болно. Энэ “бай”-г жинхэнэ үйл үгээр ч хэрэглэдэг, туслах үгээр ч хэрэглэдэг. Туслах үгээр хэрэглэхэд энэ үндэс нь өмнөх үйл үгийн “ж, аад, саар” дагавартай нийлж, байдлын утга илтгэдэг. “Бай” гэдэг үйл үг нь үйл үгийн янз бүрийн хувиллаар хувилж, үйл үгийн бусад айн утгыг илрүүлдэг. Энэ байдал заах “бай” гэдэг туслах үйл үг ярианы хэлэнд дагавар болж хувилсан байна. Тиймээс ярианы хэлэнд дагаврын аргаар байна гэж үзэх нь зохистой юм (ӨМИС-ийн Дундад улсын хэл бичиг, утга зохиолын салбарын Монгол хэлний тасаг, 1964: 479) гэж үзжээ. Тулгуур, Галсан “Орчин үеийн монгол хэл” гэх номдоо монгол хэлэнд “ж ч, аад, ээд, саар, сээр” дагавар бүхий нөхцөл үйл үгийн дараа “бай” гэдэг туслах үйл үгийг хэрэглэж, байдлын утгыг илтгэнэ (2006:257) гэж үзжээ. Түмэнжаргал “Одоо үеийн монгол хэл” гэх номдоо монгол хэлэнд “- жу, жү / -чу, чү /, - аад / - ээд, - саар /- сээр” нөхцөл бүхий нөхцөл үйл үгийн дараа “бай” язгуурт үгийг хэрэглэж, байдлын утгыг илтгэдэг (2018:236) гэх мэтчилэн тайлбарласан байна.

2.1. Үргэлжлэн үйлдэж байх байдал

Үзэмчин аман ярианд үргэлжлэн үйлдэж байх байдлын утгыг [-ʃɛː,-ʃiː,-ʃlɛː] зэрэг дагавраар илтгэдэг. Цэнгэлтэй “Одоо үеийн монгол хэлний зүй (нэмэн зассан хэвлэл)” гэх номдоо үргэлжлэн үйлдэж байх байдлын утга илтгэмжийн хувьд, энд зэрэгцэх нөхцөл үйл үгийн “-ж” хэлбэр нь зөвхөн холбох үйлдлээрээ байж байх ба тэмдэг үйл үгийн “бай” нь хэрэг юмны оршиж бүхийг илтгэдэг байснаасаа энд утга нь бага хувирч, дээрх үйлдээ үргэлжилж байх хэлний зүйн утга нэмж өгчээ. Ингээд нийтдээ гол үйл үгийн үргэлжилж байх байдлыг үзүүлэх болжээ. Нэлээд аман аялгуунд “-ж бай” гэсэн хэлбэр нь нягтарч нийлээд бараг байдалт үндсийн дагавар шиг болчихжээ (2000:292) гэж үзсэн.

2.1.1 Үргэлжлэн үйлдэж байх байдлын [-ʃɛː,-ʃiː] дагавар

Үзэмчин аман ярианд [-ʃɛː,-ʃiː] дагавраар үргэлжлэн үйлдэж байх байдлын утгыг илтгэдэг. Энэ нь зэрэгцэх нөхцөл үйл үгийн “жу, чу” хэлбэрийн дараа “бай” гэдэг туслах үйл үгийг хэрэглэж, тухайн үйлийг үргэлжлэн үйлдэж байх

утгыг илтгэнэ (Тулгуур, Галсан, 2006:257-258). Жишээлбэл:

ən alβən kərth pi: sʊ:ʃi:n, ʃhəkə:t xun xar irβyl ənt ʊlʃʃi:n.

Энэ албан гэрт би сууж байна, тэгээд хүн хар ирвэл энд уулзаж байна.

Naɣən ʃuβə:t kʊrəβ ərəkʃ xʊ:xʊn xurkʊn xəjiri: aɣʊ:lʃi:n.

Нар зөвөөр гурав эргэж, хүүхэн хүргэн хоёрыг ариулж байна.

Koʃʊ:n ʃʃuk ətə: pas turə:sʊn tʰʏrʏk kuitʃi:n.

Хошуун зүг одоо бас түрээсэн тэрэг гүйж байна.

Tʰər ʃhA:n sʊ:kA:t kar ʊtʰəs ərəltʃi:n.

Тэр цаана суугаад гар утас оролдож байна гэх мэт.

2.1.2 Үргэлжлэн үйлдэж байх байдлын [-ʃʃle:] дагавар

Үзэмчин аман ярианд бас [-ʃʃle:] дагавраар үргэлжлэн үйлдэж байх байдлын утга илтгэдэг. Энэ нь бичгийн хэлэнд “-жу” дагавраар хэлбэржсэн үйл үгийн дараа сул үг “л” дагаж, хойно нь “бай” язгуурт үйл үг орж, үйл үгийн үргэлжлэн үйлдэж байх байдлын утгыг илтгэхтэй адил юм. Жишээлбэл:

Sulʃʃə:nt tʰər sɛ:xən sɛ:xən ʃʃʌŋ mʌʃʌŋ tʰɛβʃʃle:n.

Сүлжээнд тэр сайхан сайхан зуушийн муушийн (сүүдэр) тавьж л байна.

Ətə: ʃhʲin pas nisklə:t pərə: ərʊ:lən kət jertʃʃle:n.

Одоо чинь бас нисгэлээр бороо оруулна гээд ярьж л байна.

Tʰər ərʲlis uxuru:t ʃhʲin jamər tʰokli:ʃhʲin kət xama: ukue: xuxu:lʃʃle:n.

Тэр эрлийз үхрүүд чинь ямар тугалыг чинь гээд хамаагүй хөхүүлж л байна.

Pi: ətə: xʊ:xʏt xarəx nasna:sa:n oŋkorʃh, ətə: tokʊɛ: pəjə:n sœβlə:t sʊ:ʃʃle:n.

Би одоо хүүхэд харах наснаасаа өнгөрчихжээ, одоо дуугүй биеэ сувилаад сууж л байна гэх мэт.

Үзэмчин аман ярианд үргэлжлэн үйлдэж байх байдлын утгыг илтгэх [-ʃʃle:] дагавар нь бас аман ярианд дургүйцсэн эсвэл, ёжилсон санаа бүхий таашаалын бус утгаар хэрэглэгддэг байна. Жишээлбэл: [ʃhʲi: xune: xəlxi: sɔnskʰʊ: A:ʃilʃʃle:] (Чи хүний хэлэхийг сонсохгүй аашилж л бай), [xune: sɛ:n mʊ:ki: mətʃkʰu: jɛβʃʃle:n] (Хүний сайн, мууг мэдэхгүй явж л байна), [ʃhʲi: ətə: pas A:β ə:ʃi:nkʰə:n ərʊ:k xara:t sʊ:ʃʃle: nʊ:] (Чи одоо бас аав, ээжийнхээ эрүүг хараад сууж л байна уу) гэх мэт.

2.2 Давтан үйлдэх байдал

Давтан үйлдээд байх байдал нь урьдчилах нөхцөл үйл үгийн “-аад, -ээд” нь туслах үйл үгийн “бай”-тай нийлж, нэг зүйлийн шинэ утгыг бий болгожээ. Энэ нь үйлийн дахин давтаад л байхыг илтгэнэ (чухалчлахын тусад ямагт дунд нь “л” оруулна) (Цэнгэлтэй, 2000:292). Үзэмчин аман ярианы давтан үйлдээд байх байдлын утгыг [-A:tle: /-ə:tle: /-ɔ:tle: /-o:tle:], [-A:te: /-ə:te: /-ɔ:te: /-o:te:] зэрэг дагавраар илтгэдэг.

2.2.1 Давтан үйлдээд байх байдлын [-A:tle: /-ə:tle: /-ɔ:tle: /-o:tle:] дагавар

Үзэмчин аман ярианд [-A:tle: /-ə:tle: /-ɔ:tle: /-o:tle:] дагавраар дахин үйлдээд байх байдлын утгыг илтгэдэг. Энэ нь үнэндээ бичгийн хэлэнд “-аад, -ээд” дагавраар хэлбэржсэн үйл үгийн дунд сул үг “л” дагаж, хойно нь “бай” язгуурт үйл үг орж, үйл үгийн дахин үйлдээд байх байдлын утгыг илтгэхтэй адил юм.

Жишээлбэл:

Pəɾɔ: xʊɾ ɔɾʃʃ jɛtɑ:tɬɛ:xi:, ʃɑmɛɾ ʊxɑ:nʰɛ:ki: pit pɑs mətʰuɛ:.

Бороо хур орж ядаад л байх юм, ямар ухаантайг бид бас мэдэхгүй.

Tʰɛɾi: pɑs ju:n piʃʰɛ:tɬɛ:xi: tɛ:rʏn nɛɾ pɛ:n.

Тэрийг бас юу нь бичээд л байх вэ, дээр нь нэр байна.

Tʰɑmɛk nɛk sɑβ ɑββɛl xɛɾɛn ʃɔ:s, ɛŋkʰɛ:t ɔtɔ: ʃɔ:sʃʰin pɑk pɑkɑ:t ɔɾɔ:tɬɛ:nɑ:.

Тамхи нэг сав авбал хорин зоос, ингээд одоо зоос чинь бага багаар ороод л байна.

Tʰɛɾ ɑɬɛk ʊxʊɾ ʃʰin ɔtɔ: xuitʰni: tɑ:kkʰʊ:, tɔɬʏn xɔltɔ:tɬɛ:n.

Тэр алаг үхэр чинь одоо хүйтнийг даахгүй, төл нь хөлдөөд л байна гэх мэт.

Байцаалтаар илрүүлсэн нь, үзэмчин аман ярианд цөөнх тохиолдолд [-ɑ:tɬi: /-ɛ:tɬi: /-ɔ:tɬi: /-o:tɬi:] хэлбэрээр дахин үйлдээд байх байдлын утгыг үзүүлдэг. Тус дагавар нь өмнөх эрдэмтдийн хэлний зүйн судалгааны бүтээлд ер дурдагдаж байгаагүй. Энэ нь мөн бичгийн хэлний “-аад, -ээд” дагавраар хэлбэржсэн үйл үгийн дунд сул үг “л” дагаж, хойно нь “бай” язгуурт үйл үг орж бүтсэн юм. Жишээлбэл: [nʊtʰɛk kʊikɑ:t jɛβɑ:tɬi:ʃɛ:] (нутаг гуйгаад яваад л байжээ), [ʊjɑ:nɑ:sɑ:n ʃʊtʰkɛ:tɬi:n](уяанаасаа зүтгээд л байна), [xʊnɛ: jimi: ɔjɔ:tɬi:sɛn](хүний юмыг оёод л байсан), [ʃʊnɛ: ʃʰɛk xɛn ʃʰin pɑs ɔtʰo:tɬi:n] (Зуны цаг хонь чинь бас өтөөд л байна) гэх мэт.

2.2.2 Давтан үйлдэх байдлын [-ɑ:tɛ: /-ɛ:tɛ: /-ɔ:tɛ: /-o:tɛ:] дагавар

Үзэмчин аман ярианд [-ɑ:tɛ: /-ɛ:tɛ: /-ɔ:tɛ: /-o:tɛ:] дагавраар дахин үйлдээд байх байдлын утгыг илтгэдэг. Энэ нь бичгийн хэлэнд “-аад, -ээд” дагавраар хэлбэржсэн үйл үгийн дараа “бай” язгуурт үйл үг орж, үйл үгийн дахин үйлдээд байх байдлын утгыг илтгэж буй. Жишээлбэл:

Mɔŋkɛl mɛɾ ʃʰin pɑs ʊɾɬɑ:n mʊɾɬɑ:nɑ:t ʃɑŋ ɑβɑ:tɛ:nɑ:.

Монгол морь чинь бас уралдаан муралдаанаар шан аваад байна.

ʃʰil ɔɾβɛl xʊn ɔɾʃʃ ɑβʃʰiɾɑ:t xi:lkɛ:tɛ:n.

Жил орвол хүн урьж авчраад хийлгээд байна.

ʃʰil pɔlkɔni: pʊɾ ɔɾʊɬɔ:tɛ:x piʃ ʃʰiʊ:.

Жил болгоныг бүр оруулаад байх биш шүү.

Pɑɾɑ: ʊʃʊmʃʰine: xɑn ʊ:l ɛn tʰɛɾɛ:t xɛl jɛɾɑ:n pɑs ʃʰɔɾɔ:tɛ:n.

Баруун үзэмчний Хан-Уул энэ тэрээр хэл яриа нь бас зөрөөд байна гэх мэт.

Тодорхойлууштай нь, [-ɑ:tɛ: /-ɛ:tɛ: /-ɔ:tɛ: /-o:tɛ:] дагавар нь дахин үйлдээд байх байдлын утгыг илтгэдгээр үл барам нэг үйлийг нэгэнт үйлдээд байх байдлын утгыг ч үзүүлдэг юм. Гэтэл нэгэнт үйлдээд байх байдлын утгыг илтгэхдээ тус хэлбэрийг заавал [-ɑ:t pɛ: /-ɛ:t pɛ: /-ɔ:t pɛ: /-o:t pɛ:] гэх мэтчилэн тодорхойгоор авиалдаг юм. Жишээлбэл: [nɑɾ kɑɾxɑ:s ʊmʊn ʊ:lɑ:n kɑɾʃʰkɑ:t pɛ:sɑn] (Нар гарахаас өмнө ууландаа гарчхаад байсан), [pi: ʊssɛn ʃʰin tʰɛɾ xʊɾɛ:t pɛ:ʃʃ] (Би үзсэн чинь тэр хүрээд байжээ) ... гэх мэтчилэн илтгэдэг. Энэ [-ɑ:tɛ: /-ɛ:tɛ: /-ɔ:tɛ: /-o:tɛ:] дагавар нь үнэндээ нэг үйлийн гүйцэтгэх ба үргэлжлэх хоёр зүйлийн байдлын утгыг бүр илтгэж байна.

2.3 Үргэлжлэн үйлдсээр байх байдал

Үзэмчин аман ярианы үргэлжлэн үйлдсээр байх байдлын утгыг олонх тохиолдолд [-sa:ri: /-sə:ri: /-sɔ:ri: /-so:ri:] зэрэг дагавраар илтгэдэг. Энэ нь бичгийн хэлэнд “-саар, -сээр” дагавраар хэлбэржсэн үйл үгийн дараа “бай” язгуурт үйл үг орж, үйл үгийн үргэлжлэн үйлдсээр байх байдлын утгыг илтгэхтэй адил байдаг. Жишээлбэл:

nat^hk^hu: pe:sa:ri:ka:t mar^ha:t okson.

Наадахгүй байсаар байгаад мартаад өгсөн.

Jum jumi: oxotf issə:ri:kə:t i:m pəlf^hikf.

Юм юмыг ухаж идсээр байгаад ийм болчихжээ.

T^hər f^hin əssə:ri:kə:t sur mət^hfⁱ:n.

Тэр чинь очсоор байгаад сүр мэдэж байна.

f^hamt okso:ri:kə:t ɔtə: tɔ:slə:.

Чамд өгсөөр байгаад одоо дууслаа гэх мэт.

Тодорхойлуштай нь, үзэмчин аман ярианы үргэлжлэн үйлдсээр байх байдлын утгыг [-sa:ri: /-sə:ri: /-sɔ:ri: /-so:ri:] зэрэг дагавраар илтгэхээс гадна, заримдаа [-sa:r pe: /-sə:r pe: /-sɔ:r pe: /-so:r pe:] дагавраар ч илтгэдэг. Тухайлбал, [a:β f^hin xənt jeβsa:r pe:ka:t pur mət^hfⁱ:n] (Аав чинь хонинд явсаар байгаад бүр мэдэж байна), [əni:f^hin ə:rsə:r pe:ka:t ɔlə:t əβla:] (Энийг чинь эрсээр байгаад олоод авлаа), [t^hət f^hin kuβu: ɔrsə:r pe:ka:t xun pur t^hent^hfⁱ:n] (Тэд чинь хошуу орсоор байгаад хүн бүр таньж байна), [əŋk^hə:t xo:so:r pe:t^həl nək mɛərt^hæ: xun nɛ:ʃi:n iɣʊn] (Ингээд хөөсөөр байтал нэг морьтой хүн нааш ирнэ) гэх мэт. Гэтэл тус дагаврын хэрэглэгдэх байдлыг [-sa:ri: /-sə:ri: /-sɔ:ri: /-so:ri:]-тай харьцуулбал тийм идэвхтэй биш. Үүнд, [-sa:r pe: /-sə:r pe: /-sɔ:r pe: /-so:r pe:] дагавар нь урд өмнөх үзэмчин аман ярианы судалгааны бүтээлд дурдагдаагүй, байцаалтаар илрүүлсэн дагавар болно.

Задлаг хэлбэр болон дагаварт хэлбэр нь гадар хэлбэр дээрээ байгуулалт нь адил үгүй боловч хэрэг дээрээ их ойролцоо юм. Учир нь, байдлын дагаварт үндэс нь мөн ч задлаг хэлбэрээс түүхийн явцад хөгжиж ирсэн ба нөгөө талаар, одоогийн задлаг хэлбэрийн зарим нь нягтарч нийлээд бараг үндэс, дагаврын харьцаатай болох шахсан байна (Цэнгэлтэй, 2000:293-294).

Гурав. Давталтын аргаар байдлын айг илтгэх

Үзэмчин аман ярианы давталтын аргаар үзүүлэх байдлын айд голдуу удаан үргэлжлэх, удтал үргэлжлэх, олонтоо дахин үйлдэх байдал багтана. Монгол хэлэнд үйл үгийг давтаж, үйлийн янз бүрийн байдлын утгыг үзүүлэх ёс бий. Үйл үгийг давтахдаа голдуу нөхцөл үйлийн зэрэгцэх, урьдчилах, хам ба үргэлжлэх нөхцөл үйл үгийн хэлбэрийг хоор хооронд нь давтах бөгөөд давтсан хэлбэрийн адилгүйгээс болж, утга нь хоорондоо бага ялгаатай болдог (Хас-Эрдэнэ, Гончигсүрэн, Сунрав, Сэцэн, Даваадагва, Тогоо, Наранбат, 1996: 480-481).

3.1 -sa:r /-sə:r /-sɔ:r /-so:r дагаварт үгийг давтах

Үзэмчин аман ярианд удаан үргэлжлэх байдлын утгыг [-sa:r /-sə:r /-sɔ:r /-so:r]

хэлбэрт үйл үгийг давтах аргаар нэг үйл хөдөлгөөний удаан үргэлжлэх байдлын утгыг гаргана. Бичгийн хэлэнд үргэлжлэх нөхцөл үйлийн “-саар + саар, -сээр + сээр”-ийн нийлэмжээр тэмдэглэж буй. Жишээлбэл:

T^hər ʃAβərt manɛ: mal ʃAβərssa:r ʃAβərssa:r milə:n xərəktʃɛ:.

Тэр шаварт манай мал шавардсаар шавардсаар нэлээд хорогджээ.

Ən ʃɔxɔ:lɔ:n pissə:r pissə:r ɔtɔ: parək хэтүн ʃil pəlssən pa:.

Энэ зохиолоо бичсээр бичсээр одоо бараг хэдэн жил болчихсон ба.

Tal naji xurtʃi:x nast^hnu:tɑ:r tœ:rsɔ:r tœ:rsɔ:r ən ʃ^hin jix jim œ:lkəx pəlʃɛ:.

Дал ная хүрч байх настнуудаар тойрсоор тойрсоор энэ чинь их юм ойлгох болжээ.

T^hər joti:n uit ʃfərəm ɛ:lɔ:tən xurka:ni: xolto:so:r xolto:so:r jix Alu:lʃ ʃiʊ:.

Тэр зудын үед зарим айлууд нь хургаа хөлдөөсөөр хөлдөөсөөр их алуулж шүү гэх мэт.

Нэг үйлийн удаан үргэлжлэх байдлын утгыг [-sa:r /-sə:r /-so:r /-so:r] хэлбэрт үйл үгийг давтаж илтгэхээс гадна бас туслах үгийн аргаар илтгэж болдог. Үүний тухай На.Гэрэлт: “Монгол бичгийн хэлний зүйн судлал” гэх номдоо үргэлжлэх нөхцөл үйлийн хувилал нь энгийн холбох нөхцөл үйлийн хувиллын адил бие даасан хоёр үйл үгийг, эсхүл, бие даасан үйл үг ба туслах үйл үгийг хооронд нь холбож өгнө. Дангаараа байвал байдлын утгыг илтгэх нь гол болох бөгөөд энэ онцлогоосоо болж, нэг үйл үгээ энэ хэлбэрээр хэлбэржүүлж давтал удаан үргэлжлэх байдлын утгыг гаргана (1998: 258) гэж үзсэн.

3.2 “-ʃ” дагаварт үйл үгийг давтах

Үзэмчин аман ярианы удтал үргэлжлэх байдлын утгыг мөн бичгийн хэлнийх шигээ “жу” хэлбэрт үйл үгийг давтах аргаар нэг үйлийн алгуур удтал үргэлжлэх байдлын утгыг илтгэнэ. Жишээлбэл:

T^hər sɛ:n mət^hu: jim ʃ^hin utʃiʃ utʃiʃ ʃ^hA:ʃi:n jɛβA:t oklo:.

Тэр сайн мэдэхгүй юм чинь үзэж үзэж цаашаа яваад өглөө.

Ən usru: Atu: ʃ^hin ɔrtʃ ɔrtʃ ʃ^hA:ʃi:n tɛxA:t kA:rA:t kuikə:t kaləx ʃuk jɛβA:.

Энэ ус уруу адуу чинь орж орж, цаашаа дахиад гараад гүйгээд халх зүг явлаа.

Unu:x ʃ^hin ʃ^himə: kue: sɔ:ʃ sɔ:ʃ nək jim pɔtɔ:t ɔlʃɛ:.

Өнөөх чинь чимээгүй сууж сууж нэг юм бодоод олжээ.

T^hər ʃ^hA:ʃi:n jɛβʃ jɛβʃ kə:nt^hk^hʏn ʃɔksɔ:t o:ri:nk^ho:n jɛrA:t ixəllə:.

Тэр цаашаа явж явж гэнэт зогсоод өөрийгөө яриад эхэллээ гэх мэт.

3.3 Олонтоо дахин үйлдэх байдал

Адил үндэс бүхий үйл үгэнд “н” ба “-аад /-ээд”-ийг тус тус залган давтах аргаар тухайн үйлийн олонтоо дахин үйлдэх байдлыг илрүүлнэб (Тулгуур, Галсан, 2006:258-259).

Тодруулбал, орчин цагийн монгол хэл аялгуунд хам нөхцөл үйлийн “н + н” хэлбэр ба урьдчилах нөхцөл үйлийн “аад + аад, + ээд + ээд” хэлбэрийг давтаж, олонтоо дахин үйлдэх байдлын утгыг илтгэнэ. Үзэмчин аман ярианы олонтоо дахин үйлдэх байдлын утгыг бичгийн хэлнийх шигээ [-n] хэлбэрт үйл үг ба [A:t /

ə:t / ɔ:t / o:t] хэлбэрт үйл үгийг давтах аргаар илтгэдэг. Жишээлбэл:

Tʰər ʃə:r mər ʃʰin tʰorne: təkʰu:r nəkʃʰ tʰorkʰo: kaɾa:t kaɾa:t jeβʃʰikən.

Тэр зээр мэхээр чинь торны дээгүүр нэг ч торохгүй гараад гараад явчихна.

ən əβo:k tʰextək tətʰyn ənt pɛ:ʃɛ:ka:t ʃʰa:ʃi:n nu:kə:t nu:kə:t jeββəl
xœ:ʃʰisən xurʃʰ tʰexən.

Энэ овоог тахидаг дээд нь энд байж байгаад цаашаа нүүгээд нүүгээд явбал
хойчис нь хүрч тахина.

ulsu:t o:ri:n a:ssən xuf muʃʰə:n kalt nɔʃʰə:ko:t nɔʃʰə:ko:t oroktoko:n orkon.

Улсууд өөрийн аваачсан хүж мүжээ галд ноцоогоод ноцоогоод өргөдгөө
өргөнө.

Pitʰu:nɛ: maɣa:n əxtʰələ:t əxtʰələ:t xun pəlkənt nək xœβi:n oko:t oko:t jeβu:ltək
pɛ:ʃʰ.

Битүүний махаа огтлоод огтлоод хүн болгонд нэг хувийг нь өгөөд өгөөд
явуулдаг байжээ.

Ni:kymlyki:n tu:ʃʰit su:ltə:n jeβən jeβən əʃʰiɾo:t irlə:.

Нийгэмлэгийн дуучид сүүлдээ яван яван олшроод ирлээ.

Ko: li: tɛ:ka:ni: tʰər uityn pɛrən pɛrən puʃʰa:ʃʰin.

Гуу ли дэй (өндөр хүүтэй зээллэг)- гээ тэр үед нь барин барин буцаачихна
гэх мэт.

Үзэмчин аман ярианы олонтоо дахин үйлдэх байдлын утга илтгэх “аад + аад,
ээд + ээд” хэлбэр нь заримдаа ардаа олноор үйлдэгдэх хэвийн дагавар “жгаа,
жгээ / цгаа, цгээ”-г дагуулан олон тооны эзэн этгээдийн тус тусынх нь үйл явдлыг
заана. Үүнд, дөхөм жишээлбэл, [tʰət ʃʰin xœβ xœβnɛ:xa:n jɛɾa:t jɛɾa:t su:ʃʰka:ʃʰlɛ:n]
(Тэд чинь хувь хувийнхийгаа яриад яриад сууцгааж л байна), [ulsu:t ɔtə: pur pətə:t
pətə:t arəkkʰu: xulə:ʃʰkə:ʃʰlɛ:n] (Улсууд одоо бүр бодоод бодоод аргагүй хүлээцгээж
л байна) гэх мэтээр хэрэглэгддэг байна.

Үзэмчин аман ярианд хэвийн дагавар болон байдлын дагавар давхарлан
хэрэглэгдэнэ. Чингэхэд хэвийн дагаврын дараа байдлын дагавар орохоос биш,
байдлын дагаврын дараа хэвийн дагавар орж хэрэглэгддэггүй (Хөхбарс, Чимэг,
1997:102) ⑮. Үүнд, үйл үгийн адил бус хэвт үндэст үгэнд адил бус байдлын
дагаврыг давхарлах буюу угсран залгаж болдог. Энэхүү хэлбэрийг хэлний
шинжлэлд хэв ба байдлын дагаврын “нийлмэл хэлбэр” гэж нэрийдэж болмоор,
зарим эрдэмтэд иймэрхүү үзэгдлийг бас “давхарлагдал”, “угсрал” гэх мэтээр
дууддаг бий. Тодруулбал, голдуу үйлдүүлэх хэв + үйлдчих байдал; үйлдүүлэх
хэв + үйлдэгдэх байдал; үйлдэгдэх хэв + үйлдсээр байх байдал; үйлдүүлэх хэв +
үйлдэгдэх хэв + үйлдсээр байх байдал; үйлдэгдэх хэв + үйлдүүлэх хэв + үйлдсээр
байх байдлын дагаврууд нийлж хэрэглэгддэг. Тухайлбал, [tʰər xunə:r jɛɾu:ʃʰix]
(Тэр хүнээр яриулчих), [kəʃʰə:l ɔɾβəl ɔɾu:la:tʰax] (Хичээл орвол оруулаадах), [tʰər
ʃʰin aβtʰəksa:r pɛ:ka:t sur xəʃʰirtʃʰ] (Тэр чинь автагдсаар байгаад сүр хаширчихжээ),
[məɾyktʃil ʃʰin ɔtə: sɛ:ʃʰiɾu:ləksa:r aʃʰil jix urəkʃʰtʰɛ: pəlsən] (Мэргэжил чинь одоо
сайжруулагдсаар ажил их урагштай болсон), [oŋkorsonɛ: oʃʰiri:n pətəktu:lso:r tʰər

o:ri:n эгэх кие: хaрэмсән](Өнгөрсний учрыг нь бодогдуулсаар тэр өөрийн эрхгүй харамсана) гэх мэт.

Хураангуйлбал, тус өгүүлэлд голдуу үзэмчин аман ярианы үйл үгийн байдлын айг дагаврын арга, туслах үгийн арга, давталтын аргаар хэрхэн илтгэж байгаа тухай шинжилж, жишээлэн тодруулсны дагуу, урд өмнөх үзэмчин аман ярианы судалгаанд илрээгүй үйл үгийн байдлын айн зарим дагавар ба эрдэмтдийн зарим үзэлтийн тойронд өөрийн өчүүхэн бодол саналаа солилцжээ. Үнэндээ монгол хэлний үйл үгийн хэлний зүйн айн чухал бүрэлдэхүүн болох байдлын айг үйл үгийн төлөвийн ай ба хэвийн айнуудтай харьцуулбал туйлын будилаантай нэг зүйлийн ай гэж үзэж болмоор. Учир нь тэмдэг үйл үг ба нөхцөл үйл үгэнд бас байдлын утгыг илтгэдэг дагавар нэлээд байгаа юм.

Ном зүй

Ном

- Гэрэлт, На.**, (1998), *Монгол бичгийн хэлний зүйн судлал*, Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо.215, 258-р нүүр. [Gerelt, Na., (1998), *Mongol bichgiin helnii züin sudlal*, Övör Mongolin Ih Surguuliin hevleliin horoo] [Research on Mongolian Written Grammar, Inner Mongolia University Press]
- Лувсанвандан, Ш., Болд, Л.**, (найр.) Сэцэнбаатар, Б., Жимс, (хөрвүүл.) (1991), *Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй*, Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 286-р нүүр. [Luvsanvandan, Sh., Bold, L., (nair.), Setsenbaatar, B., Jims, (hörvүүл.), (1991), *Mongol helnüüdiin har-itsuulsan hel züi*, Övör Mongolin surgan хүмүүжлийн hevleliin horoo, 286-р нүүр] [Comparative Studies of Mongolian Languages, Inner Mongolia Education Press]
- Өвөр Монголын Их Сургуулийн Дундад улсын хэл бичиг, утга зохиолын салбарын Монгол хэлний тасаг**, (1964), *Одоо үеийн монгол хэл*, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 479-р нүүр. [Övör Mongolin Ih Surguuliin Dundad ulsin hel bichig, utga zohiolin salbarin Mongol helnii tasag, (1964), *Odoo üyiin mongol hel*, Övör Mongolin ardin hevleliin horoo, 479-р нүүр.] [Mongolian Language Room, Department of Chinese Language and Literature, Inner Mongolia University Modern Mongolian Language, Inner Mongolia People's Press]
- Тулгуур, Галсан**, (2006), *Орчин үеийн монгол хэл*, Ляонингийн үндэстний хэвлэлийн хороо, 257, 257-258, 258-259-р нүүр. [Tulguur, Galsan, (2006), *Orchin üyiin mongol hel*, Lyaoningiin үндэстний hevleliin horoo, 257, 257-258, 258-259-р нүүр.] [Modern Mongolian Language, Liaoning Nationalities Publishing House]
- Түмэнжаргал**, (2018), *Одоо үеийн монгол хэл*, Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо, 236-р нүүр. [Tümenjargal, (2018), *Odoo üyiin mongol hel*,

Övör Mongolin Ih Surguuliin hevleliin horoo, 236-r нүүр.] [Modern Mongolian Language, Inner Mongolia University Press]

Цэнгэлтэй, (2000), *Одоо үеийн монгол хэлний зүй* (нэмэн зассан хэвлэл), Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 292, 292, 293-294-р нүүр. [Tsengeltei, (2000), *Odoo üyiin mongol helnii züi* (nemen zassan hevlel), Övör Mongolin ardin hevleliin horoo, 292, 292, 293-294-r нүүр.] [Modern Mongolian Grammar (Revised Edition), Inner Mongolia People's Press]

Хас-Эрдэнэ, Гончигсүрэн, Сунрав, Цэцэн, Даваадагва, Тогоо, Наранбат, (1996), *Орчин цагийн монгол хэл (засаж найруулсан дэвтэр)*, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 480-481-р нүүр. [Has-Erdene, Gonchigsüren, Sunrav, Tsetsen, Davaadagva, Togoo, Naranbat, (1996), *Orchin tsagiin mongol hel (zasaj nairuulsan devter)*, Övör Mongolin surgan хүмүүжлийн hevleliin horoo, 480-481-r нүүр.] [Modern Mongolian (Revised edition, Inner Mongolia Education Press]

Өгүүлэл

Батгэрэл, (1995), *Монгол хэлний үйл үгийн байдлын айн дагаварт холбогдох зарим асуудлын тухай*, Монгол хэл, утга зохиол, 2-р хугацаа. [Batgerel, (1995), *Mongol helnii үйл үгийн baidlin ain dagavart holbogdoh zarim asuudlin tuhai*, Mongol hel, utga zohiol, 2-r hugatsaa.] [Some Problems concerning the Categories of Verbal Aspects in Mongolian Language, Mongolian Language And Literature, Issue 2.]

Норжин, Ц., (1991), *Одоо үеийн монгол хэлний үйл үгийн бүтэц - бичгийн хэлний материалд үндэслэв* (үргэлжлэл), Монгол хэл бичиг, 2-р хугацаа. [Norjin, Ts., (1991), *Odoo üyiin mongol helnii үйл үгийн бүтэц- bichgiin helnii material үндэслэв (үргэлжлэл)*, Mongol hel, bichig, 2-r hugatsaa.] [Modern Mongolian Verb Structure - Based on Written Language Data (Continuation)", Mongolian Language, Issue 2.]

Хөхбарс, (1991), *Үзэмчин аман аялгууны авиа, хэлний зүйн чухал онцлог*, Монгол хэл, утга зохиол, 1-р хугацаа. [Höhbars, (1991), *Üzemchin aman ayalguunii avia, helnii züin chuhal ontslog*, Mongol hel, utga zohiol, 1-r hugatsaa.] [Important Characteristics of Phonetics and Grammar in the Ujimqin Dialect , Mongolian Language and Literature, Issue 1.]

Хөхбарс, Чимгээ, (1997), *Үзэмчин аман аялгуу*, Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо, 102 дугаар нүүр. [Höhbars, Chimgée, (1997), *Üzemchin aman ayalguu*, Övör Mongolin Ih Surguuliin hevleliin horoo, 102-r нүүр.] [Ujimqin dialect, Inner Mongolia University Press]

Abstract:

This paper combines the application characteristics of the situation category of Ujimqin colloquial verbs with the explanations in the previous research results of

scholars, and illustrates meaning of the suffixes [-ʃʰik, -ʃʰək] in the Perfective aspect, the suffix [-βəskə:] in the Momentance aspect, the suffixes [-A:tli: / -ə:tli: / -o:tli: / -o:tli:] in the Iterative aspect and the suffixes [-sA:r pɛ: / -sə:r pɛ: / -so:r pɛ: / -so:r pɛ:] in the Continuative aspect, which have not appeared in the previous research results of the situation category of Ujimqin colloquial verbs. This paper probes into the above suffixes and launches its own immature and superficial views on some suffixes in the state category of verbs explained in the works of scholars.

Keywords: Ujimqin dialect; Verb state; Application



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.